МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 31 өдөр Дугаар А/547 Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2008 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн №126 дугаар захирамжаар газар эзэмшигч хуулийн этгээд "Хөвсгөл аймгийн бурхан шашинтны төв Мөрөнгийн хүрээ гандан даржайлин хийд" шашны байгууллага (РД:8001472)-ын Мөрөн сумын 1 дүгээр багт байршилтай "Гандан-2"-ын 204 тоот хаягтай, сүм, хийд, шашны байгууллагын зориулалттайгаар эзэмшүүлсэн 6712008722 нэгж талбарын дугаартай газрын талбайн хэмжээ захирамжаар 51776 м^2 гэснийг кадастрын хэмжилтээр 47821 м^2 гэж өөрчилж үлдсэн 5 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн №126 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшигч хуулийн этгээд "Хөвсгөл аймгийн бурхан шашинтны төв Мөрөнгийн хүрээ гандан даржайлин хийд" шашны байгууллага (РД:8001472)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат)-т үүрэг болгосугай

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

6712011229